

ЦӨМИЙН ҮНДСЭН БА ӨНДӨР ӨДӨӨГДСӨН  
ТӨЛӨВИЙН АЛЬФА ЗАДРАЛ  
Г.Хүүхэнхүү, Г.Үнэнбат  
(МУИС, Цөмийн шинжилгээний төв)

### 1. ОРШИЛ

Цөмийн цацраг идэвхжилийг 1896 онд Францын эрдэмтэн А.Беккерель нээснээс [1] хошиг удалгүй, цөмөөс турван төрлийн цацраг гардгийг тогтоож [2], тэлгээрний альфа, бета, гамма гэж тус тус нэрэлзэн билээ, 1932 онд нейтрон нээгдсэн дараа альфа бөөм гээд нь хоёр протон, хоёр нейтронос тогтсон гелийн цөм болох нь нотлогдов. Онгөрсөн хугацаанд альфа задралыг олон эрдэмтэн судалж, түүний танин мэдээ ўйл явцын хувьд түүхэн хэд хэдэн үе шатыг түүлжээ [3-5]. Гэвч одоо болтол альфа задралын онол бүрэн боловсроогүй, шийдвэл зоих асуултууд байсаар байна.

Цацраг идэвхжил нээгдсэн 100 жилийн ойд зориулсан энэ бяахан тэмдэглэлд цөмийн үндсэн ба өндөр өдөөгдсөн төлөвийн альфа задралын зарим онцлогийг авч үзээд, шинжээчдийн сонирхлыг татсан, одоогоор шинэдэгдээгүй байгаа хэдэн асуудалд уншигчийн анхаарлыг хандуулахын эрмэлзэв.

### 2. ЦӨМИЙН ҮНДСЭН БА ӨДӨӨГДСӨН ТӨЛВИЙН АЛЬФА ЗАДРАЛЫН МАГАДЛАЛ

Цөмийн альфа задрал болох магадлалыг хоёр магадлалын үржвэр хэлбэрээр дараах байдалтай илэрхийлж болно [4].

$$\lambda_a = f_a \cdot T_a \quad (1)$$

Үүний  $\lambda_a$  – задралын тогтмол,  $f_a$  – цөмд дөрвөн нуклон нээлж альфа бөөм бүрэлдэх магадлал,  $T_a$  – үүссэн альфа бөөм цөмийн үйлчлэлийн хүрээг нэвтрэн гарах магадлал (нэвтрэх коэффициент).

1936 онд Н.Борын дэвшүүлсэн компаниуд цөм үүсэх таамаглал ёсоор [6] нейтроны үйлчлэлээр цөмөөс альфа бөөм гарах урвалын магадлал буюу огтголыг хоёр магадлалын үржвэр хэлбэртэй бичиж болно:

$$\sigma_{n\alpha} = \sigma_n(c) \cdot G_a \quad (2)$$

Энд  $\sigma_n(c)$  – бай цөм дээр нейтрон тусч компаниуд цөм үүсэх огтмол,  $G_a$  – компаниуд цөмөөс альфа бөөм гарах магадлал. Энэ магадлалыг дараах илэрхийллээр тодорхойлдог:

$$G_a = \frac{\Gamma_a}{\Gamma} \quad (3)$$

Үүний  $\Gamma_a$  – цөмийн төвшний альфа задралд харгалзах өргөн,  $\Gamma$  – төвшний нийт өргөн. Гейзенбергийн тодорхой бусын зарчим ёсоор

$$\Gamma_a \cdot \tau_a \approx \hbar. \quad (4)$$

Энд  $\tau_a$  – тухайн төвшний альфа задралд харгалзах нас (задрахгүй байх хугацаа). Эндээс задралын тогтмолыг олвол:

$$\lambda_a = \frac{1}{\tau_a} = \frac{\Gamma_a}{\hbar} = f_a \cdot T_a \quad (5)$$

(1), (2), (3), (5) томъёонуудаас хараад цөмийн үндсэн ба өндөр өдөөгдсөн төлвийн альфа задрал нэгэн ижил  $f_a \cdot T_a$  үржвэрээр илэрхийлэгдэж байна.

### 3. НЭВТРЭХ КОЭФФИЦИЕНТ

Нэвтрэх коэффициент  $T_a$  – ийг альфа бөөм цөмийн гадаргуу дээрээс буцаж ойх, төвөөс зутгах болон Кулоны орны саадуудыг нэвтрэх магадлалуудаар тодорхойлж болно. Цөмийн гадаргуугаас альфа бөөм гэдэггүй ойхгүй (абсолют хар цөм) гэж үзвэл  $T_a$  – ийг Дж. Расмуссены томъёогоор бодож болно [7,8]. Үндсэн төлөвтөө байгаа цөмийн альфа задралын нэвтрэх коэффициентийг бодсон зарим үр дүнг 1-р хүснэгтэд жагсаав. Энд  $T_{1/2}(a)$  – альфа хагас задралын ўе.

Дулааны нейтроныг атомын цөм шинжээж өндөр өдөөгдсөн төлөвт ороод альфа бөөм цацуруулах үзэгдлийн нэвтрэх коэффициентийг тооцоолсон зарим утгудыг 2-р хүснэгтэд үзүүлэв. Энэ хоёр хүснэгтээс хараад альфа бөөмийн нэвтрэх коэффициент үндсэн төлөвт байнаасаа өндөр өдөөгдсөн төлөвт орсноор аравын гуч гаруй зэрэг дахин өөрчлөгджэй байна. Иймд үндсэн ба өдөөгдсөн төлөвтүүдийн альфа задралын харьцуулан судалхад тэлгээрийн нэвтрэх коэффициентийг зөв тооюх явдал онцгай үзүүлэв. 1-р хүснэгтэд байгаа Nd-144-ийн  $T_a$  их зөрөтэй байгааг тэмдэглэв. Гэвч энэ зөрөө цаащины тооцоонд нөлөөлэхгүй. 2-р хүснэгтэд эх бидний тооцоолсон  $T_a$  Дж. Расмуссены утгуудаас бага зэрэг зөрөтэй байгаагийн учир нь уг тооцоонд хэрэглэгдэж байгаа зарим хэмжигдэхүүн орчин ўед нарийвчлагдаж өөрчлөгдсөнтэй холбоотой.

1-р хүснэгт Цөмийн үндсэн төлвийн альфа задралын нэвтрэх коэффициент

| Задарч буй<br>цөм | $E_a$ (МэВ) | $T_{1/2}(a)$<br>(сек) | $T_a$                 |                       |
|-------------------|-------------|-----------------------|-----------------------|-----------------------|
|                   |             |                       | [7]                   | Бидний<br>тооцоо      |
| Nd-144            | 1.83        | $1.58 \cdot 10^{13}$  | $2.18 \cdot 10^{-42}$ | $4.67 \cdot 10^{-45}$ |
| Sm-146            | 2.55        | $1.58 \cdot 10^{15}$  | $1.19 \cdot 10^{-34}$ | -                     |
| Sm-148            | 1.96        | $2.52 \cdot 10^{12}$  | -                     | $1.62 \cdot 10^{-44}$ |
| Gd-148            | 3.18        | $4.47 \cdot 10^9$     | $7.52 \cdot 10^{-30}$ | -                     |
| Hf-174            | 2.50        | $9.50 \cdot 10^{22}$  | $5.44 \cdot 10^{-43}$ | -                     |
| U-234             | 4.77        | $7.83 \cdot 10^{12}$  | $2.34 \cdot 10^{-33}$ | -                     |
| U-238             | 4.20        | $1.41 \cdot 10^{17}$  | $7.67 \cdot 10^{-38}$ | -                     |

2-р хүснэгт Өндөр өдөөгдсөн төлвийн альфа задралын нэвтрэх коэффициент

| Компаунд ном | E <sub>a</sub> (МэВ) | l <sub>a</sub> | T <sub>a</sub> , 10 <sup>-6</sup> |               |
|--------------|----------------------|----------------|-----------------------------------|---------------|
|              |                      |                | [16]                              | Бидний тооцоо |
| Zn-68        | 4.60                 | 3              | -                                 | 4.85          |
| Mo-96        | 6.39                 | 2              | -                                 | 2.29          |
| Ru-97        | 6.33                 | 0              | 3.17                              | 2.50          |
| Te-124       | 7.33                 | 0              | 2.07                              | 0.40          |
| Nd-144       | 9.45                 | 3              | 3.60                              | 1.27          |
| Sm-148       | 9.84                 | 3              | 2.48                              | 1.46          |
| Sm-150       | 9.21                 | 3              | 0.47                              | 0.17          |
| Gd-156       | 7.93                 | 1              | -                                 | 0.22          |

4. АЛЬФА БӨӨМ БҮРЭЛДЭХ ФАКТОР

Дөрөн иуклон нэгдэж альфа бөөм бүрэлдэх магадлал буюу факторыг хялбар үзэлэх зорилго тавь. Эхээд цөмийн үндсэн төлвөөс альфа задрал болох үзэглийг авч үзэ. Нэгж хугацаанд цөмд альфа бөөм үүсч магадлалыг, цөмийн потенциал саадлын ханыг альфа бөөм дотроос нь ирж мөргөх давтамжаар илрэхийлвэл:

$$f_a = \frac{1}{l_a} = \frac{1}{\left(\frac{2R}{V_a}\right)} = \frac{\hbar}{2mR^2} \quad (6)$$

Энд l<sub>a</sub> – потенциал саадлын хананы хооронд альфа бөөм хөдлөх ўе, 2R – потенциал саадлын диаметр, V<sub>a</sub> – потенциал саад логорхи альфа бөөмийн хурд, m – альфа бөөмийн масс. Эндээс  $f_a \approx 10^{21} \cdot c^{-1}$  (7) гарна.

Цөмийн урвалын статистик онол ёсоор [9]:

$$\langle \Gamma_a \rangle = D \cdot \frac{l_a}{2\pi\hbar} \quad (8)$$

Үүний  $\langle \Gamma_a \rangle$  – цөмийн түвшний альфа өргөний дундаж утга, D – цөмийн төвшинүүдийн хоорондох зайны дундаж. (5) ба (8) – аас

$$f_a = \frac{D}{2\pi\hbar} \quad (9)$$

болов нь харгадана. Үндсэн төлвийн хувьд D = 1 MeV гэвэл [10] мөн  $f_a \approx 10^{21} \cdot c^{-1}$  болж (7) –той төхирч байна. Физик утгаараа f<sub>a</sub> "цөмийн хутацааны" урвуутаар тодорхойлогдж болох нь (6) – аас харгдана.

Өөрөөр хэлбэл (6) ба (7) ёсоор цөм дотор альфа бөөмийн хурд гэрлийн хурдал маш ойрхон байна.

(5), (7) илрэхийлүүд ба 1-р хүснэгтийг ашиглан хагас задралын үеийг үнэлэе.

$$T_{1/2}(\alpha) = \frac{0.693}{\lambda_a} = \frac{0.693}{(f_a T_a)} = \frac{0.693}{(10^{21} \cdot c^{-1} \cdot T_a)} \quad (10)$$

Уран-238 изотопын хувьд T<sub>o</sub> = 7.67 10<sup>38</sup> гээд

$$T_{1/2}(\alpha) = 10^{16} \text{ с}$$

болно. Бүдүүэг үнэлгээ гэхэд 1-р хүснэгт дэх утгаас хол зөрөхгүй байна.

Одоо өндөр өдөөгдсөн төлвийн хувьд буюу компаунд цөмийн альфа задралын авч үзье. (9) томъёоны D = 10 эВ [11] гэвэл өндөр өдөөгдсөн төлвийн хувьд

$$f_a \approx 10^{15} \cdot c^{-1} \quad (11)$$

болж, компаунд цөмийн амьдрах хутацааны дундаж уттын урвуутаар илрэхийлэгдэж байна. Цөмийн урвалын статистик онол ёсоор [9]

$$\langle \Gamma_a^2 \rangle = 2 \langle \gamma^2 \rangle \cdot T_a \quad (12)$$

Энд  $\gamma^2$  – цөмийн төвшний хураангуйлсан альфа өргөн. (5) ба (12) илрэхийлүүдээс

$$f_a = \frac{2 \langle \gamma^2 \rangle}{\hbar} \quad (13)$$

болно. Энд  $\langle \gamma^2 \rangle \approx 1 \text{ эВ}$  [11] гэвэл  $f_a \approx 10^{15} \text{ c}^{-1}$  гарч (11) – тэй тохирч байна.

5. Nd-144 ЦӨМИЙН АЛЬФА ЗАДРАЛ

Nd-143 цөм дээр удаан нейтрон тусаад өндөр өдөөгдсөн төлвийн байгаа компаунд цөм Nd-144 үүсдэг. Тэгвэл Nd-143 дээр удаан нейтроноор явагдах (n,α) урвалыг Nd-144 цөм өндөр өдөөгдсөн төлвөөсөө альфа задрал болж байгаа мэт үзж болно [12]. Нэгэв талаас, Nd-144 цөм үндсэн төлвийт байхдаа альфа илэвхжнэгээ тул Nd-144 дээр үндсэн ба өндөр өдөөгдсөн төлвүүдийн альфа задралыг шууд харьцуулах боломж гарыи байна.

Эхлээд С.Г.Кадменский, В.И.Фурман нарын боловсруулсан кластер загварыг [13] ашиглай. Уг загвар ёсоор спектроскопийн фактор S<sub>a</sub>-ыг ашиглан альфа задралыг дараах байдлаар түрэв ангиж болгог:

$$S_a = \frac{\Gamma_a^{\text{exp}}}{\Gamma_a^{\text{theor}}} = \begin{cases} 10^{-4} & \text{хагас зөвшнөөрөгдсөн} \\ 10^{-6} & \text{хоринотой} \end{cases} \quad (14)$$

Үүний  $\Gamma_a^{\text{exp}}$  – түршлэгээр тодорхойлсон альфа өргөн,  $\Gamma_a^{\text{theor}}$  – альфа кластер ортон. Компаунд цөм Nd-144-ийн хувьд  $\langle \Gamma_a(Z) \rangle = 14 \cdot 10^{-6}$  эВ [12] ба  $\Gamma_a^{\text{theor}} = 3.9$  эВ [13] учир

$$S_a^c = 3 \cdot 10^{-6} \quad (15)$$

болж, хориотой алфа задрал гэдэг ангилалд орж байна. Үндсэн толвөөсөө задарч буй Nd-144-ийн хувьд

$$S_a^G = \frac{\langle \Gamma_a \rangle}{\langle \Gamma_a^{cl} \rangle} = \frac{\langle \gamma_a^{2cl} \rangle}{\gamma_a^{2cl}} = 3 \cdot 10^{-3} \quad (16)$$

гарч, зөвшөөрөгдсөн алфа задрал болов. Энд бил үндсэн төлвийн алфа задралын хураангуйласан өргөн [7]

$$\delta_a^2 = \frac{\lambda_a}{T_a} \cdot h \quad (17)$$

гэдэг хэмжигдэхүүнийг ашиглав. (5), (13) ба (17) томъёонудаас

$$\langle \gamma_a^{2cl} \rangle = \frac{\delta_a^2}{4\pi} \quad (18)$$

болно. [7] өгүүлэлд  $\delta_a^2 = 8.3 \text{ кэВ}$  гэснийг авч (16) томъёонд орлуулав. Вингерийн хэзгаар [14]

$$\langle \gamma_a^{2cl} \rangle = \frac{3h^2}{2\mu_a R^2} \quad (19)$$

—ыг авч (16) томъёоны хуваарлыг орлуулав. Энд  $\mu_a$  - алфа бөөмийн эмхэтгэсэн масс,  $R$  - цөмийн радиус. Ийнхүү (15) ба (16)-ийн харьцаа

$$\frac{S_a^G}{S_a^c} \approx 10^3 \text{ гарав.} \quad (20)$$

Одоо Р.Бонети, Л.Милазо-Коли нарын "алфа бөөм бүрэлдэх" загварыг [15] ашиглан, Nd-144 цөмийн алфа задралд анализ хий. Дээрх спектроскопийн фактортой төстэй алфа задралын буюу алфа бөөмийн хүчиний функци гэдэг хэмжигдэхүүнийг авч үзэвэл, үндсэн төлвийн хувьд

$$S_a^G = \frac{\delta_a^2}{D_o} \quad (21)$$

бөөгдсөн төлвийн хувьд

$$S_c = \frac{\delta_c^2}{D_c} \text{ болно.} \quad (22)$$

Дөрвөн нуклон нийлж алфа бөөм үүсгэдэг учир нэг бөөмөөс тогтсон Ферми-хийгээс 4 дахин зөрүүтэй байх ёстой гэвэл Nd-144 цөмийн үндсэн төлвийн орчим төвшнүүдлийн хоорондох дундаж зай

$$D_G = \frac{4}{\rho_F} = \frac{4\pi^2}{6 \cdot \left(\frac{A}{8}\right)} \text{ МэВ} = 0.4 \text{ МэВ} \quad (23)$$

Үүний  $\rho_F$  - Ферми-хийн төвшний нягт,  $A$  - цөмийн масс тоо.

Компаунд Nd-144-ийн хувьд [11]-ээс

$$D_c(3) = 0.7 \cdot 10^{-4} \text{ МэВ} \quad (24)$$

гэж олдоно. Хураангуйласан алфа өргөннийг үндсэн төлөвт [7]

$$\delta_a^2 = 8.3 \cdot 10^{-3} \text{ МэВ} \quad (25)$$

компаунд цөмд

## ABSTRACT

The alpha decay of ground and high excited states is considered from the view-point of statistical model as two independent processes: perforation of alpha particle on the nucleus and penetration of the alpha particle through centrifugal and Coulomb barriers. The reformation and penetration factors are calculated for the alpha decay of the ground and high excited states. The alpha decay of the ground and high excited states of Nd-144 nucleus was analysed using the cluster model and performed alpha particle model. It was showed that the results obtained by these models are different.

## АШИГЛАСАН НОМ ХЭВЛЭЛ

1. А.Н.Вескерел. Comptes Rendus. 1896
2. M.Curie. Radioactivite. 1935, Paris
3. И.Перлман, Дж.Расмуссен. Альфа–радиоактивность. Перевод с английского. изд. ИЛ, 1959, Москва
4. Дж.Расмуссен Альфа–распад. В кн: "Альфа, бета и гамма–спектроскопия". Под ред. К.Зигбана. Атомиздат, 1969, Москва, Том 2, с.137
5. Дж.К.Ханна. Альфа–радиоактивность. В кн: "Экспериментальная ядерная физика", Под ред. Э.Сегре, изд. ИЛ, 1961, Том 3, с.57
6. N.Bohr. Nature, vol.37 – '36, p.344
7. J.O.Rasmussen. Phys.Rev. vol.113, №6, 1959, p.1593
8. G.Khuukhenkhouu, I.Chadraabal. Scientific Journal. Mongolian State University. (This number).
9. J.M.Blaett, V.F.Weisskopf. Theoretical Nuclear Physics. 1952. New York
10. Б.Н.Андреев, С.М.Сироткин. Ядерная физика, том1, №2, 1965, с.252
11. S.F.Mughabghab. Neutron Cross Sections. vol.1, BNL, Upton, New York, 1981. Academic Press.
12. Г.Хүүхэнхүү. Сечение реакции ( $n,\alpha$ ) на ядрах редких земель в области энергии нейтронов 30 кэВ. Диссертация на соискание ученой степени к.ф.м.н. 1980, Дубна
13. С.Г.Кадменский, В.И.Фурман. Альфа распад и родственные ядерные реакции. 1985, Москва
14. A.Arima et al. Advances in Nucl.Phys., vol.5, 1972, p.449
15. R.Bonetti, L.Milazzo-Colli. Phys. Lett. vol. 49B, №1, 1974, p.17
16. R.D.Griffen, J.O.Rasmussen, R.D.Macfarlane. Chemistry Division Annual Report. University of California. UCRL-9566, 1960.

МУИС, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ №2(125), 1996

## МОНГОЛ ОРОН ДАХЬ ГАЗРЫН ГАДАРГА ОРЧНЫ ИНВЕРСИ

М.Цоозол

Агаарын температур тропосферт босоо чиглэлд 100 м тутамд дунджаараа 0,6°C-аар буурлаг ба тухайн үеийн шаг уурын нөхцөл, орон нутгийн онилог зэрэг хүчин зүйлсээс хамаарч аллагдана. Босоо чиглэлд агаарын температур борчлогдохгүй үеийн изотерм—(ижил температурын)—ийн, ихсэж байгаа үеийг инверси—(температурын босоо чиглэл дэх тонгоруу)—ийн давхарга эзж нээрэлдэг.

Инверси нь агаарын босоо чиглэл дэх хөдөлгөөнийн saatуулагч ўбох учир утга уинаар, тоос широ агаарт удаан хугацаагаар халгалагдаж хот суурин газрын агаарыг бохирдуулах, говь хөндийд хүйтний улиралд мосон манан (маар) ўтсэх нөхцлийг бүрдүүлэв. Ийм инверсийн судалгаа нь газрын гадарга орчны агаарын ўтсэх давхаргын шаг уурын судалгааны чухал зүйлсийн нэг бөгөөд хот сууринийн байришт төлөвлөх, агаар манилсын бохирдолгоос хамгаалах, бэлчээрний мал аж ахуй голлон эрхэлж байгаа манай орчны нөхцөлбөль малын хашах саравчийг байрлуулах газрын сонгох, малын бэлчээрийг зохицтай ашиглах, тухайн газар нутгийн уур амьсгалын нөөцийг зөв ўнэлэхэд зайлшгүй шаардлагатай асуудал юм.

Орцил угсралын иловеэллөөс хамаарч өндрийн инверси ўсдэг бол газрын гадарын инверси хөвчилэн дэвсгэр гадаргын онцлогтой холбоотой ўсдэг. Төв Азийн уулзархаг мүжид оршиг манай орчны хувь уул нууруулын хоорондох холой хөндийн өвөрмөс байрлал, хүйтний улирлын эсэх шиклоны сууриншилтай тогтоц нь инверси ўтсэх аятай нөхцлийг бүрдүүлэв.

Судлаачдын [3,4] гаргасан дүнгээс үзвэл Их нууруудын хоттор ба Туулын сав хөндийд 15-17°C хүртэл эрчимтэй 1500-3000 м зузаантай инверси овлийн улиралд ўсдэг байна.

Энэхүү огтүүлэлд инверсийн аэро-ур амьсгалын зарим горимын тухай Алтай, Улаангом, Даланзадгад, Сайншанд, Улаанбаатар, Морон, Арвайхээр, Чойбалсан зэрэг аэробогийн станцуудын 1968-1973, 1976-1977, 1987-1990 оны мэдэг ашиглан гаргасан үзүүлэлтүүдийг огүүлэв.